



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
 ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/136

Шивээговь сум

Сумын Засаг даргын “Жуух бичиг”-ээр  
 шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5, сумын Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/15 дугаар захирамжаар батлагдсан “Сумын Засаг даргаас олгох шагналын журам”-ын 2.1.3, 5.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сум, орон нутагтаа идэвх санаачлагатай ажиллаж, спортын төрөлд гаргасан хувь нэмрийг нь үнэлэн 1 дүгээр багийн иргэн Одхүүгийн Эрдэнэбаярыг Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнасугай.

2. Шагналд зарцуулагдах 30,000 (гучин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг нягтлан бодогч (Б.Түвшинжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Холбогдох ажлыг зохион байгуулж, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг нягтлан бодогч (Б.Түвшинжаргал), Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Алтансүх) нарт, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА